



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2021.05.01 № 05/7515
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн салбарын нэгдсэн төлөвлөлт, хөрөнгө оруулалт хариуцсан шинжээчээр томилогдохоор нэр дэвшсэн Пүрэв-Очирын Дэлгэрмаа, Төрийн захиргааны удирдлагын газрын салбарын шагнал хариуцсан ахлах мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Дүгэржавын Даваасамбуу нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

Харин албан бичигт дурдсан Салбар хяналтын газрын эрсдэлийн бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Самдангийн Түмэн-Өлзийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон шаардлагатай бусад мэдээллийг Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд мэдүүлээгүй байх тул хянан үзэх боломжгүй байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Т.ЭНХБОЛД

142303007565